



НИЙСЛЭЛИЙН  
НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2018 оны 02 сарын 09 өдөр

Дугаар А/06

Улаанбаатар хот

Хариуцлагатай эргүүл  
томилох тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Сар шинийн баярыг тохиолдуулан нийслэлийн засаг захиргааны байруудын инженерийн байгууламжийн хэвийн, найдвартай ажиллагааг хангах, байруудын дотоод журмын хэрэгжилтэнд тавих хяналтыг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Нийслэлийн засаг захиргааны байруудад амралтын өдрүүд болон цагаан сарын амралтын өдрүүдэд хариуцлагатай эргүүлээр ажиллах албан хаагчдын нэрсийг нэгдүгээр, дундын үйлчлэгчийн хуваарийг хоёрдугаар, цахилгаанчны хуваарийг гуравдугаар, сантехникийн слесарийн хуваарийг дөрөвдүгээр, хянагч операторын хуваарийг тавдугаар, лифтчины хуваарийг зургаадугаар, харуул жижүүрийн хуваарийг долоодугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Нийслэлийн засаг захиргааны байруудын цахилгаан, дулаан, усан хангамжийн хэвийн жигд ажиллагааг хангаж, гал усны гамшгийн аюулаас урьдчилан сэргийлж, харуул хамгаалалтын албаны ажилтнуудтай хамтран ажиллаж, гарсан зөрчил доголдлыг шуурхай барагдуулж, шаардлагатай арга хэмжээг цаг алдалгүй авч ажиллахыг нийт албан хаагчдад үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж, хэрэгжилтийн талаар удирдлагад танилцуулж ажиллахыг Байр ашиглалтын албаны дарга /М.Мөнхсүрэн/, Дотоод хяналт хариуцсан ажилтан /Ч.Шинэчимэг/ нарт тус тус даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Х.ЭРДЭНЭБИЛЭГ



1150500011